ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ ОНӨААТҮГ

# 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

## НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХҮРЭЭНД

Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан "Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр", Агаарын тухай хууль, МУ-ын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол болон бусад холбогдох хууль, тогтоомжийг мөрдүүлэх замаар агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан.

Зорилт 1. Монгол хэл, бичгээ үндэсний үнэт зүйлийн бүрдэл болгон иргэн бүр чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшүүлэх зорилтын хүрээнд

*Арга хэмжээ 1.1.* Үндэсний Монгол бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшүүлэх ажлыг зохион байгуулна.

2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр байгууллагын үндсэн ажилчид, 7 Дүүргийн мэргэжилтнүүдийн дунд Архив, албан хэрэг хөтлөлт, Монгол бичгийн сургалтыг зохион байгуулсан. Нийт 21 албан хаагчийг хамруулсан. Хүний нөөцийн мэргэжилтэн, Архив, бичиг хэргийн мэргэжилтэн Үйлдвэрийн газрын даргын тушаал, явсан бичгийг Монгол бичгээр давхар хөтлөн явуулж байна.



*Зураг 1 Монгол бичгийн сургалт*

**Зорилт 2.** Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын заалтэй орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд

*Арга хэмжээ 1.2.* Албан хаагчдын биеийн тамир, спортын идэвхийг дэмжин, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх зорилгоор 7 хоног бүр спорт заал ашиглах нөхцөлөөр

хангах

Нийслэлийн Баянгол дүүргийн 47 дугаар сургуультай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, ажилтнуудын биеийн тамир, спортын идэвхийг дэмжин эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх зорилтын хүрээнд 7 хоног бүрийн баасан гаригт спортын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.



*Зураг 2 биеийн тамир, спортын өдөр*

**Зорилт 3.**Ногоон хөгжлийн бодлого зорилтын хүрээнд

*Арга хэмжээ 1.3.* "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг үргэлжлүүлэх ажлын хүрээнд

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдөр бүх албан хаагчдыг хашаандаа мод тарихыг уриалж нийт 1230 ширхэг шар хуайс, хайлаас мод тарьсан.



*Зураг 3 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн*

## ХОЁР. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

**Зорилт 1.** Үйлдвэрийн газрын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах зорилт арга хэмжээний хүрээнд

*Арга хэмжээ 2.1.1 Үйлдвэрийн газрын ажлын гүйцэтгэл, бүтээмжийг сайжруулах, хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах үүднээс компьютер, техник хэрэгслийг шинэчлэх, шаардлагатай тоогоор нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.*

Үйлдвэрийн газрын ажлын гүйцэтгэл, бүтээмжийг сайжруулах, хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах зорилгоор компьютер, техник хэрэгслийг үе шаттайгаар шинэчилж, шаардлагатай тоогоор нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулсан. Үүний хүрээнд хуучирч, ашиглалтын шаардлага хангахгүй болсон техник хэрэгслийг шинэчлэн, өндөр хүчин чадалтай 15 компьютеруудыг суурилуулж, ажиллах нөхцөлийг сайжруулсан. Мөн холбогдох дагалдах төхөөрөмжүүдийг шинэчлэн, сайжруулснаар үйлдвэрийн газрын үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах нөхцөл бүрдсэн.



*Зураг 4 Сүлжээний шинэчлэл*

*Арга хэмжээ 2.1.2 Үйлдвэрийн газрын хяналтын процессыг сайжруулах зорилгоор операторуудыг нэгдсэн хяналтын дэлгэцээр хангах*

2018 онд "Таван Толгой Түлш" ХХК байгуулагдах үед ашиглаж байсан хуучин техник, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчилж, сайжруулсан. Үүний хүрээнд өндөр хүчин чадалтай 5 ширхэг компьютер, 20 ширхэг чихэвч, хяналтын дэлгэцийг шинэчилснээр дэлгэцийн операторуудын ажлын орчин нөхцөл сайжирч ажлын бүтээмж нэмэгдсэн.

Өдөр тутмын үйл ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, осол, зөрчлийн шалтгааныг тодорхойлох, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Үйлдвэрийн

газар болон 6 дүүргийн ажлын байранд нийт 15 ширхэг хяналтын камерыг суурилуулсан.



*Зураг 5 Дэлгэцийн операторуудын ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан*

*Арга хэмжээ 2.1.3 Цахилгаан тасалдал, хүчдэлийн хэлбэлзэл үүссэн үед байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах, хяналтын үйл ажиллагаа тасалдалгүй, хэрэглэгчийн дуудлага, мэдээллийг цаг алдахгүй авах , тасралтгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд тог баригч (UPS) төхөөрөмжөөр суурилуулах.*

Цахилгаан тасалдал, хүчдэлийн хэлбэлзэл үүссэн үед байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах, хяналтын үйл ажиллагаа тасалдалгүй, хэрэглэгчийн дуудлага, мэдээллийг цаг алдахгүй авах , тасралтгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд APC's Smart-UPS RT, 5000VA, 230V загварын RITAR 12v 100AH батарейтай, тог баригч төхөөрөмжийг 2025 оны 10 дугаар сарын 20-ний өдөр Үйлдвэрийн газарт байршуулсан. Энэ төхөөрөмж нь 4 цагийн турш тасалдалгүй ажиллах хүчин чадалтай. Цахилгааны хязгаарлалтын үед ППМ өссөн угаарын дуудлагыг алдахгүй авах, техник тоног төхөөрөмж гэмтэх эрсдэлээс хамгаалах ач холбогдолтой.





*Зураг 6 APC's Smart-UPS RT төхөөрөмжийн суурилуулалт*

Удаан хугацаанд цахилгаан тасарсан үед тасралтгүй цахилгаанаар хангах дизель хөдөлгүүрт автомат асаалтын систем, сэлгэн залгалт, дуу намсгагч хайрцагтай, тосол халаагчтай 30кат генераторыг 2025 оны 10 дугаар сарын 25-ний өдөр байршуулсан. Энэ нь үйлдвэрийн газрын үйл ажиллагаа доголдохоос сэргийлэх, ППМ өссөн дуудлагыг цаг

алдалгүй авч иргэдийг утаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлж, эрсдэл үүсэхээс хамгаалах, дуудлага мэдээлэл алдахгүй, төхөөрөмж гэмтэх эрсдэлийг бууруулсан.



*Зураг 7 Дезиль генерато суурилуулсан*

*Арга хэмжээ 2.1.4 Үйлдвэрийн газрын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд зориулж физик серверт шинэчлэлт хийх.*

Мобинетэд байршиж буй 2 Физик сервер насжилтын хувьд дууссан буюу өндөр ачаалал дааж чадахгүй болсон байснаас үүдэн 51,000 ширхэг утаар мэдрэгч төхөөрөмж айл өрхүүдэд суурилуулах үед ачааллаа дийлэхгүй, хэт халалтын улмаас эвдрэл гарч 2 ширхэг РАМ буюу шуурхай санах ой хайлсан байсныг "ИНТЕЛЛИГЕНТ" ХХК-тай хамтран шуурхай санах ойг сольж серверийг хэвийн ажиллагаанд оруулах ажлыг 2025 оны 05 дугаар сард зохион байгуулсан.

Сүлжээний инфраструктурын цогц аудит хийж, үйлдвэрийн газрын дотоод болон гадаад сүлжээний орчныг шинжлэн үнэлснээр түүний аюулгүй байдал, найдвартай ажиллагаа, бүтээмж, дүрмийн дагуу байдлыг үнэлж, одоогийн алдаа дутагдал, эрсдэлүүдийг илрүүлэн, засвар сайжруулалтын боломжуудыг тодорхойсон.

Серверийн аюулгүй байдлын firewall-г сайжруулан олон улсын стандартын дагуу **ISO/IEC 2700** Серверт firewall-ийг ажиллагаанд оруулсан. Серверийг 2026 онд Нийслэлийн мэдээлэл технологийн газарт шилжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.



*Зураг 6 Сервер дээр хол болт хийгдсэн*

Үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад өндөр хурдны интернэт шаардлагатай тул хуучин хурдыг сайжруулж, зөвхөн дэлгэцийн операторуудын компьютер 20Mbps хурдыг очихоор зохицуулалт хийн үлдсэн 30Mbps хурдыг бусад компьютерт, 3 утасгүй интернэт цацагч төхөөрөмжийг байршуулж интернэт цацалт хүрдэггүй байсан хэсгүүдэд жигд хүргэдэг болсон. Үүний үр дүнд дэлгэцийн операторууд угаарын дуудлагыг цаг алдалгүй авах нөхцөл бүрдсэн.

Цахилгаан доголдол үүсэж эргээд хэвийн болох үед дотоод сүлжээний хаяг (IP ADDRESS) солигдон интернэт өгч буй гадаад хаягтай (IP ADDRESS) зөрдөг байсан гэмтлийг илрүүлэн, эвдрэлтэй свич буюу сүлжээ салаалагч төхөөрөмж болон рүүтэр утасгүй интернэт цацагч төхөөрөмжийг сольсон.



*Зураг 9 Рүүтэр буюу утасгүй интернэт цацагч төхөөрөмж*

**Зорилт 2.** Программ хангамжийн болон нийгмийн сүлжээний хэвийн тасралтгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлж байнгын хяналтын тогтолцоог бий болгох зорилт арга хэмжээний хүрээнд

*Арга хэмжээ 2.2.1 Tttservice.mn серверийн болон программ хангамжийн доголдлын алдааг бүрэн дуусгаж, хөгжүүлэлтийг үргэлжлүүлэх.*

"Таван толгой түлш" ХХК-аас "Интелгент" ХХК-д 2020 онд анхны ажлын даалгавраар www.tttservice.mn системд 20 хэрэглэгч зэрэг хандах боломжтой байхаар хийгдсэн нь техникийн шаардлагын зөрүү үүсгэж, Мобинетэд байршсан хоёр физик серверт их хэмжээний ачаалал өгдөг, сервер унтрах болон түр хугацаанд ажиллагаагүй болох эрсдэл бий болсон. Уг асуудлыг шийдвэрлэх зорилгоор "Интелгент" ХХК-тай хамтран ажилласнаар системийн хэрэглэгчийн зэрэг хандалтын тоог 200,000 болгон өргөтгөх, ачааллыг хэт өгөхгүй байхаар дахин программчлал, системд өөрчлөлт сайжруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.



*Зураг 10 www.tttservice.mn*

*Арга хэмжээ 2.2.2. Zuuh.mn серверийн болон программ хангамжийн доголдлын алдааг бүрэн дуусгаж хүлээн авах.*

www.zuuh.mn системийн хэрэглэгчийн бүртгэл дээрх алдаа болон нэмэлт өөрчлөлтүүдийг "Ди Ай Аддрэсс" ХХК-тай хамтран хийсэн. Үүнд:

Хяналтын ажилчдад тухайн хариуцсан хорооны хамрагдах өрхийн мэдээлэл харагддаг болсон. Судалгааг дахин шинэчилж оруулахад тухайн өрхийн мэдээллийн давхцал үүсдэг байсан алдааг засварласан.

Ажлаас чөлөөлөгдсөн ажилтны хариуцаж байсан айл өрхийн мэдээлэл тухайн ажилтан дээрээ түүх болон хадгалагдаж, дараагийн шинээр орж буй ажилтанд шилжихээр зохион байгуулалтыг шинээр хийсэн.

Үндсэн веб программаас өрхийн мэдээллийг эксел программруу интеграци хийхэд өрхийг давхцуулахгүй байхаар хөгжүүлэлтийг хийсэн.

Судалгаанд хамрагдаагүй өрхийг судалгаанд хамруулахад идэвхтэй төлөвт шилждэггүй алдаа гардаг байсныг арилгасан.

Айл өрхийн судалгааны тооны зөрүүг буюу давхардсан өрхийн мэдээллийн зөрчлийг арилгасан. Өрхийн болон хувь хүний мэдээллийг серверт шивэхэд үсгийн фонтыг 1 стандартад шилжүүлснээр мэдээлэл зөрөх алдаа гарахаас сэргийлсэн.

Хатуу түлш хэрэглэгч айл өрхүүдэд Давхар шаталтад зуух тарааж байгаатай холбогдуулан 2025 оны 11 дүгээр сарын 10-ний өдөр www.zuuh.mn системд нэмэлтээр 32000 давхар шаталтад зуух хэрэглэгч өрхийн цонх үүсгэж мэдээ мэдээллийг оруулан ажиллаж байна. 2025 оны 12 дугаар сарын 25-ний байдлаар 4036 өрхийн мэдээллийг оруулан ажилласан.



*Зураг 11 www.zuuh.mn*

*Арга хэмжээ 2.2.3. "Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв" ОНӨААТҮГ-ын албан ёсны вэб хаягийг нээж хөгжүүлэх, ил тод мэдээллийн системтэй холбох.*

2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 18-ний өдрийн байдлаар байгууллагын цахим хаягийн хөгжүүлэлт (frontend: HTML, CSS backend: JS, PHP, mySQL) зэрэг хэлүүд дээр бичигдэн дууссан. Үйлдвэрийн газрын цаг үеийн мэдээ мэдээлэл, шилэн дансы мэдээг цаг хугацаанд нь байршуулан ажиллаж байна.




*Зураг 12 Байгууллагын цахим хаяг буюу web хуудас*

*Арга хэмжээ 2.2.4. Нийгмийн сүлжээн дэх байгууллагын цахим хуудсын үйл ажиллагааг тасралтгүй явуулж, мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг, цахим хичээл зэрэг контентыг цаг тухайд нь нийтэлж, олон нийтэд чиглэсэн мэдээ, мэдээлэл, шторк, танин мэдэхүйн бичлэгүүдийг тогтмол бэлтгэн хүргэх.*

2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Үйлдвэрийн газрын "Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв" нэртэй пэйж хуудсыг нээж хөгжүүлэлтийг хийж эхэлсэн. Өнөөдрийн байдлаар нийт 18022 дагагчтай болж, давхардсан тоогоор 2,362,167 хүн тус хаягаар зочилж мэдээ мэдээлэл авсан байна. Мөн лайк 29117, коммент 2586, шэйр 37829 хийгдсэн.Нийт 66 рийл, 107 зурган постыг бэлтгэн олон нийтэд хүргэсэн.




*Зураг 13 Post-ууд*

2025 оны 09 дүгээр сарын 01-ны өдөр "Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв" пэйж хуудас 2200 дагагчтай байсан ба үүнээс хойш тогтмол өссөн үзүүлэлттэй байна. Хяналтын ажилтнууд болон иргэдрүү чиглэсэн мэдээ, мэдээлэл, зөвлөгөөг тогтмол хүргэж 11 сарын 27-ны өдрийн байдлаар 18022 дагагчтай болж өссөн. Нийт Пост-40, Рийл бичлэг-29, Сурвалжилга-5, Мэдээ-7 шэйр-24 орсон байна.




*Зураг 14 Аналист*

*Арга хэмжээ 2.2.5. Байгууллагын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй, ил тод, хүртээмжтэй хүргэх зорилгоор телевиз, радио болон нийгмийн сүлжээнд олон дагагчтай контент бүтээгчидтэй хамтран ажиллаж, нэвтрүүлэг, контент, видео мэдээлэл бэлтгэн олон нийтэд сурталчлан таниулах үйл ажиллагаа хэрэгжүүлэх.*

Тайлант хугацаанд sbn, ntv , mongol hd, tm tv, tv5, mnbc телевизийн мэдээнд ярилцлага өгсөн мөн Улаанбаатарын мэдээ, Чингэлтэйн мэдээ, zarig.mn, өрөг.мн мэдээллийн сайтуудад. 8 Телевиз, 4 Сайт, мөн Нийслэлийн Засаг даргын орлогч А.Амартүвшинтэй хамтран 8 удаагийн бичлэг контент бэлтгэн Нийслэлийн "Улаанбаатар мэдээ" пэйж хуудсаар цаг үеийн нөхцөл байдал, сэрэмжлүүлэг зөвлөгөө, мэдээллийг хүргэсэн. TV-9 телевизийн "MONGOL COMMENT" нэвтрүүлгээр угаар мэдрэгч төхөөрөмжийг зөв хэрэглэх, анхааруулах мэдээллийг хүргэсэн нь нийт 19000 хандалтыг авсан.




*Зураг 15 Мэдээллийн сайтуудтай хамтран ажилласан*

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн өгсөн үүрэг чиглэлийн дагуу 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс 25-ны өдрийг хүртэл Нийслэлийн 7 дүүргийн "Түлш борлуулах" 397 цэг дээр өглөө 09:00 цагаас эхлэн орой 22:00 цаг хүртэл 430 гэрээт Хяналтын ажилчид, оффисийн 29 ажилчид хяналт тавьж, 09,12,15,18,21 цагуудад борлуулалтын цэгийн мэдээг Нийслэлийн шуурхай штабт тухай бүрд нь мэдээллэж ажилласан.




*Зураг 16 Түлш борлуулах цэг*

**Зорилт 3.** Утаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд

*Арга хэмжээ 2.3.1 Утаарын хийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор сайжруулсан шахмал түлш хэрэглэгч айл өрхүүдийн пийшин, яндан, зуухны битүүмжийг шалгах, засвар үйлчилгээ хийх, зөв галлагааны горим, утаарын хийнээс урьдчилан сэргийлэх санамж болон заавар зөвлөмж брошюр, гар карт хэвлэж тараах*

Тайлант хугацаанд нийт 2,968 дуудлага хүлээн авснаас 2,816 дуудлагад засвар үйлчилгээ үзүүлсэн. Энэ нь нийт дуудлагын 94.9 хувийг бүрдүүлж байна. Харин 86 дуудлага буюу 2.9 хувь нь хойшлуулсан болон цуцлагдсан.
Дүүрэг тус бүрээр гүйцэтгэлийг авч үзвэл:

- Чингэлтэй дүүрэгт 506 дуудлагад засвар үйлчилгээ үзүүлж, 23 дуудлага хойшлуулсан буюу цуцлагдсан.
- Сонгинохайрхан дүүрэгт 934 дуудлагад үйлчилгээ үзүүлж, 15 дуудлага хойшлуулсан.
- Сүхбаатар дүүрэгт 228 дуудлагад үйлчилгээ үзүүлж, 5 дуудлага хойшлуулсан.
- Хан-Уул дүүрэгт 198 дуудлагад үйлчилгээ үзүүлж, 4 дуудлага хойшлуулсан.
- Налайх дүүрэгт 268 дуудлагад үйлчилгээ үзүүлж, цуцлагдсан дуудлага гараагүй.
- Баянгол дүүрэгт 96 дуудлагад үйлчилгээ үзүүлж, 5 дуудлага хойшлуулсан.
- Баянзүрх дүүрэгт 586 дуудлагад үйлчилгээ үзүүлж, 34 дуудлага хойшлуулсан байна.

Нийт дуудлагын дотор Сонгинохайрхан (31.5%), Баянзүрх (19.7%) болон Чингэлтэй дүүргүүд (17.0%) хамгийн өндөр ачааллатай ажилласан үзүүлэлттэй байна.



*Зураг 17 Засвар үйлчилгээ*

*Арга хэмжээ 2.3.2* Зорилтот бүлгийн айл өрхүүдийг угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх аяныг зохион байгуулах

Нийслэлийн Онцгой Байдлын Газар, Экологийн цагдаагийн газар, Нийслэл дүүрэг, хороодын Засаг даргын тамгын газар болон бусад байгууллагуудтай хамтран " Галлахдаа анхаарья " сэдэвт нөлөөллийн аяны хүрээнд Нийслэлийн 7 дүүргийн гэр хорооллын айл өрхүүдийг угаарын хийн хордлогод өртөхөөс урьдчилан сэргийлэх, зөв галлагааны талаар зөвлөмж зөвлөгөө өгөх, зуух яндангийн битүүмжийг сайжруулах,зуух яндангаа хөөлөх талаар иргэдэд өгөх зөвлөмж зөвлөгөө өгөх, хэвлэмэл материалаар тарааж, аман хэлбэрээр болон биечлэн заавар зөвлөгөө өгч ажилласан.Нийслэлийн 7 дүүрэгт тухайн байгууллагатай хамтран 7 удаа 1100 гаруй иргэдийг хамруулсан




*Зураг 18 Галлахдаа анхаарья зөвлөгөө*

*Арга хэмжээ 2.3.3 Zuuh.mn-д ирсэн дуудлагын тоо, байршил, ажилтан ямар засвар үйлчилгээ үзүүлснийг хянаж заавар зөвлөгөө өгөх, бүртгэл судалгаанд авах*

Гэр хорооллын сайжруулсан шахмал түлш болон хагас коксжсон түлш хэрэглэж буй өрхөд зөв галлагааны горим, угаарын хийн эрсдэлээс хамгаалах, угаарын хийн мэдрэгч төхөөрөмж ашиглах заавар зөвлөмжийг өдөр бүр өгч, засвар үйлчилгээний дуудлага мөн хяналтын дэлгэцэд ирж буй мэдээ мэдээллийг нэгтгэн гаргаж жилийн хугацаанд 81384 өрхийн 162782 иргэнийг угаарын хийн хордлогод өртөх эрсдэлээс сэргийлж, яндан хөөлж, засвар үйлчилгээ хийлгэх 3086 дуудлагыг авч ажилласан байна. Мөн 2916 айл өрхийн яндаг хөөлж засвар үйлчилгээ хийж ажилласан байна.



*Зураг 19 Засвар хийж байгаа*

| Дүүрэг | 12-р сарын 08-12-р сарын 14-ныг дуустал | | | 2025.01.01-ээс 2025.12.14 дуустал | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ирсэн | засвар хийсэн | цуцалсан буюу хойш | ирсэн | засвар хийсэн | цуцалсан буюу хойшлуулсан |
| **Чингэлтэй дүүрэг** | 16 | 14 | | 494 | 554 | 23 |
| **Сонгинохайрхан дүүрэг** | 16 | 23 | 1 | 1023 | 1025 | 16 |
| **Сүхбаатар дүүрэг** | 7 | 8 | 2 | 300 | 273 | 7 |
| **Хан Уул дүүрэг** | 12 | 10 | 1 | 244 | 232 | 5 |
| **Налайх дүүрэг** | 10 | 12 | | 342 | 310 | 0 |
| **Баянгол дүүрэг** | 3 | 0 | | 121 | 98 | 5 |
| **Баянзүрх дүүрэг** | 23 | 31 | | 847 | 721 | 35 |
| **ДҮН:** | **87** | **98** | **4** | **3371** | **3213** | **87** |

*Хүснэгт 1 2025 онд 70119410 тусгай дугаар ирсэн Засвар үйлчилгээний дуудлагын тоо*

**Угаарын дуудлагын тоон мэдээ / 2025.01.01-ээс 2025.12.14 ныг дуустал /**

| № | Дүүрэг | Угаарын дуудлагын тоо | Өртсөн хүний тоо | Угаартсан шалтгаан | | | | | | Угаарын хий мэдрэх төхөөрөмжийн төрөл | | | Нас барсан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Яндан, пийшинг хөөлөөгүй | Зуухны битүүмж алдагдсан | Яндан зуухыг салгасан, өрөө | Зуух, яндан гэмтсэн | Яндангийн хаалт сойлт хаасан | Салхинд цохиулсан буюу галлагаа | УХМ-гүй | энгийн УХМ-тэй | төхөөрөмжтэй | |
| 1 | Сонгинохайрхан дүүрэг | 184 | 530 | 40 | 41 | 32 | 9 | 39 | 23 | 126 | 7 | 51 | 13 |
| 2 | Баянзүрх дүүрэг | 111 | 351 | 20 | 30 | 22 | 11 | 24 | 4 | 73 | 7 | 31 | 3 |
| 3 | Чингэлтэй дүүрэг | 80 | 246 | 10 | 39 | 9 | 8 | 9 | 5 | 61 | 3 | 16 | 2 |
| 4 | Сүхбаатар дүүрэг | 26 | 86 | 2 | 9 | 2 | 1 | 5 | 7 | 15 | 3 | 8 | 0 |
| 5 | Хан-уул дүүрэг | 28 | 88 | 4 | 7 | 7 | 3 | 5 | 2 | 24 | 0 | 4 | 4 |
| 6 | Баянгол дүүрэг | 15 | 52 | 3 | 6 | 4 | 1 | 0 | 1 | 10 | 2 | 3 | 6 |
| 7 | Налайх дүүрэг | 36 | 103 | 11 | 17 | 4 | 1 | 1 | 2 | 15 | 1 | 20 | 2 |
| **8** | **НИЙТ** | **480** | **1456** | **90** | **149** | **80** | **34** | **83** | **44** | **324** | **23** | **133** | **30** |

*Хүснэгт 2 Угаарын дуудлагын тоон мэдээ*

*Арга хэмжээ 2.3.4 Угаарын хийн дуудлагад түргэн шуурхай арга хэмжээ авах, холбогдох албан тушаалтнуудад мэдээлэх, засварын багийг газар дээр нь ажиллуулж шалтгааныг тогтоох, иргэдэд зөвлөгөө, зөвлөмж өгөх, нөхцөл байдлын талаарх судалгаа, нэгтгэлийг боловсруулж санал дүгнэлтийг холбогдох байгууллагад тогтмол хүргэх ажлыг зохион байгуулах*

Төхөөрөмж суурилуулсан айл өрхүүдийг дэлгэцийн оператор болон дүүргүүдийн

Хяналтын ажилтан нартай айл тус бүрээр нь тулгалт хийж төхөөрөмж холбогдсон эсэх, байршлыг нь зөв тодорхойлсон, овог нэр утасны дугаар зэргийг шалгаж гарсан зөрчлийг нь цаг тухай бүрд нь засуулж ажилласан. Дэлгэцийн операторууд айл өрхүүдэд суурилуулсан 147906 ширхэг төхөөрөмжийг 24 цагаар хянаж ажиллаж байна. ППМ утга нь өндөр буюу 100 ППМ-ээс дээш үзүүлэлттэй ирж буй айл өрхүүдтэй цаг алдалгүй холбогдож, агаар сэлгэлт хийхийг зөвлөж, утсаа аваагүй айл өрхүүд рүү хариуцсан хяналтын ажилтныг явуулж шалтгаан нөхцөлийг нь тодруулж, болзошгүй угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлж ажиллаж байна.

2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 15-ний өдрийг хүртэлх Угаарын хийн хордлогод өртсөн 482 өрхийн 1458 тохиолдлыг байршлаар авч үзвэл Сонгинохайрхан дүүрэгт 38% /185 тохиолдол/ , Сүхбаатар дүүрэгт 5 % /26 тохиолдол/ , Баянзүрх дүүрэгт 23% /111 тохиолдол/, Чингэлтэй дүүрэгт 16% /80 тохиолдол/, Баянгол дүүрэгт 3 % /15 тохиолдол/, Налайх дүүрэгт 9% /37 тохиолдол/, Хан-Уул дүүрэгт 6% /28 тохиолдол/ тус тус бүртгэгдсэн байна. Угаарын дуудлагын тоогоороо Сонгинохайрхан дүүрэг тэргүүлж байна




*Зураг 20 Угаарын дуудлага*

2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025- оны 12 дугаар сарын 15-ний өдрийн 16 цагийн байдлаар угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан 482 өрхийн 1458 тохиолдол мэдээлэгдсэн







*Зураг 21 Насны бүлэг*

Угаарын хийн тохиолдлын мэдээ




*Зураг 22 Тохиолдол*

Үйлдвэрийн газарт 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025- оны 12 дугаар сарын 15-ний өдрийн 16:00 цагийн байдлаар нийслэлийн 7 дүүрэгт бүртгэгдсэн угаарын хийн хордлогод өртсөн иргэд нь дараах шалтгаан нөхцөлийн улмаас угаарын хийн хордлогод өртсөн байна.




*Зураг 23 Угаарын хийн хордлогын шалтгаан нөхцөл*




*Зураг 24 Угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн мэдээлэл*




*Зураг 25 Нас баралтын тоо*

*Арга хэмжээ 2.3.5 Хатуу түлш хэрэглэж буй айл өрхүүдийг угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зорилгоор алсын зайнаас хянах төхөөрөмжийг суурилуулах ажлыг зохион байгуулах.*

Угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг айл өрхүүдэд суурилуулахдаа гэрээг 2 хувь үйлдэж, зөв галлагааны заавар зөвлөмж хүргэж, зөвлөгөө өгсөн тухай баталгааны хуудсыг 2 хувь үйлдэн гарын үсэг зуруулж нэг хувийг хэрэглэгч нөгөө хувийг архив үүсгэн хяналтын ажилчдын ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.

2025 оны галлагааны улиралд нийт 128506 ширхэг угаар мэдрэгч төхөөрөмжийг суурилуулж www.zuuh.mn систем, ТТТ серверт төхөөрөмж хэрэглэгч айл өрхийн мэдээллийг оруулж, 24 цагаар угаар мэдрэгч төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хянаж байна.





*Зураг 26 зөвлөгөө өгсөн тухай баталгааны хуудас*

Угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг айл өрхүүдэд суурилуулж гэрээ хийж, заавар зөвлөмж өгөх хуудастай танилцуулж, айл өрхийн судалгааг шинэчлэн ажиллаж байна.










*Зураг 27 Утаарын хий мэдрэгч төхөөрөмжийг айл өрхүүдэд суурилуулж буй байдал*

"Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв" ОНӨААТҮГ нь туслан гүйцэтгэгч "Интеллгент ХХК"-ийн зохион бүтээсэн, угаарын хийн мэдрэгч "INTUM" төхөөрөмжийг 2025 оны 08 дугаар 18, 09 дүгээр сарын 25-ний өдрүүдэд нийт 61 мянган ширхэг угаарын хийн мэдрэгч төхөөрөмжийг хүлээн авч айл өрхүүдэд суурилуулах хуваарилалт хийсэн. Үүнд:Сүхбаатар дүүрэг 3000, Баянзүрх дүүрэг 23048, Сонгинохайрхан дүүрэг 15863, Чингэлтэй дүүрэг 9589, Хан-Уул дүүрэг 5000, Налайх дүүрэг 1000 ширхэг, нийт 61000 ширхэг төхөөрөмжийг айл өрхүүдэд суурилуулсан байна. Нийт 7 дүүргийн гэр хорооллын 147906 айл өрхүүдэд угаарын хий мэдрэгч төхөөрөмж суурилуулан, 24 цагаар хяналт тавин ажиллаж байна.



*Зураг 28 Хяналтын байдал*

Нийслэлийн 7 дүүрэгт 2025 оны 10 дугаар сарын байдлаар төхөөрөмжөө унтраасан 19836 өрх байсан. Угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг унтраасан айл өрхүүд рүү 7 дүүргийн Гэрээт хяналтын ажилтныг утсаар яриулж төхөөрөмжөө тогтмол ажиллуулахыг зөвлөж, дохио илгээхгүй байгаа төхөөрөмжийг тестлэн шалгаж төхөөрөмжөө тогтмол ажиллуулахыг сануулж ажиллаж байна. Сүлжээнээс салсан 27035 төхөөрөмж байснаас 2025 оны 12 дугаар сарын 15-ний байдлаар сүлжээнээс салсан төхөөрөмжийн тоо 7199 болж багассан байна. Мөн энэ хугацаанд 12637 айл өрхийн төхөөрөмжийг асаалгаж хэвийн ажиллагаанд оруулсан.Төхөөрөмжөө унтраасан 7199 айл өрхүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулахад гэртээ өвөлжихгүй болон сүлжээгүй хэсгийн өрхүүд эзэлж байна.

*Арга хэмжээ 2.3.6 Хийн түлшний угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зорилгоор алсын зайнаас хянах төхөөрөмжийг айл өрхүүдэд суурилуулах ажлыг зохион байгуулах*

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/1175 дугаар захирамжаар 5,000 айл өрхийг шингэрүүлсэн шатдаг хийн халаалтад шилжүүлэхэд нийлүүлэгчийг холбогдох хуулийн хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах үүрэг болгосон.

Техникийн тодорхойлолтод тусгагдсан шаардлагыг бүрэн хангасан Оросын Холбооны Улсын "Уст-Кутский хий боловсруулах үйлдвэр" ХХК-тай шингэрүүлсэн хий нийлүүлэх гэрээг байгуулсан.

2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Оросын Холбооны Улсын "Уст-Кутский хий боловсруулах үйлдвэр" ХХК-руу эхний 300 тонн шингэрүүлсэн шатдаг хий худалдан авах захиалга хийсэн. Захиалгын дагуу 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Сэлэнгэ аймгийн Сүхбаатар өртөөгөөр 300 тонн шингэрүүлсэн шатдаг хий хил давж ирсэн. 12 дугаар сарын 10-ны өдөр Толгойт өртөөнд 9 вагон шингэрүүлсэн шатдаг хийг Улаанбаатар Төмөр замын Толгойт өртөөнд "Таван толгой түлш" ХХК-ийн гэрээт агуулах Гор газ ХХК-ийн агуулахад хүлээн авсан.

*Арга хэмжээ 2.3.7 Агаарын бохирдлыг бууруулах, угаарын хийн хордлогоос сэргийлэх ажлын хүрээнд зорилтот бүлгийн айл өрхүүдийн зуухыг солих ажилд хяналт тавих*

Нийт 32000 ширхэг давхар шаталтат зуух-ийг 7 дүүргийн хатуу түлш түлдэг гэртэй айл өрхүүдэд суурилуулж байгаа бөгөөд уг ажлын хүрээнд 7 дүүргээс 4043 ширхэг зуухны судалгааны мэдээлэл ирүүлсэн. Ирүүлсэн судалгааны мэдээллийг zuuh.mn цахим системд шивж оруулан бүртгэж, мэдээллийн санг шинэчилсэн

*Арга хэмжээ 2.3.8 Шаардлагатай нөхцөлд 7 дүүрэгт утаарын хийн мэдрэгч төхөөрөмж болон угаарын хийн мэдрэгчийн зөв хэрэглээний талаар сургалт, сурталчилгаа зохион байгуулах, зөвлөгөө мэдээлэл хүргэх.*

Угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг айл өрхүүдэд суурилуулах талаар 2025 оны 04 дүгээр сар, 2025 оны 09 дүгээр сард 7 дүүргийн Хяналтын ажилтан нарт сургалт зохион байгуулсан. Сургалтаар дараах мэдээллүүдийг хүргэж ажилласан. Үүнд:

1. Айл өрхүүдтэй угаар мэдрэгч төхөөрөмжийг зөв суурилуулах, хэвийн ажиллагааг хэрхэн хангах зөвлөгөө мэдээллийг өгөх
2. Угаар мэдрэгч төхөөрөмж суурилуулсан өрхтэй төхөөрөмж эзэмших гэрээ хийх
3. Төхөөрөмжийг айл өрхүүдэд суурилуулахдаа гар карт дээр бүртгэл хийх, судалгааны анкет бөглөх
4. Айл өрхүүдэд төхөөрөмж суурилуулахдаа тухайн өрхөө бүртгэлд орсон эсэхийг шалгах
5. Айл өрхүүдээ ТТТ программд бүртгэж тухайн өрхийнхөө байршлыг оруулах







*Зураг 29 Хяналтын ажилтан нарт тэхөөрөмж суурилуулах талаар зөвлөгөө өгч буй байдал*

"Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв"ОНӨААТҮГ-ын "Интеллигент технологи" ХХК-ны үйл ажиллагаатай танилцан тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх уулзалтыг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтаар ТТТ серверт хэрэглэгчийн бүртгэл хийхэд "Ё" үсгээр эхэлсэн хүний нэр болон регистрийн дугаарын "Е" үсгийг бичдэг болгох, эрсдэлтэй айл өрх рүү залгахад хэн гэдэг оператор ярьж байгаа нь мэдэгддэггүй учраас нэг өрхтэй 2 оператор давхцаж ярих асуудал гардаг үүнийг шийдвэрлэх, айл өрхийн ППМ утга өндөр орж ирээд тухайн өрх рүү ярьсан боловч дахин 59 минутын дараа хяналтын самбар дээр өмнөх байсан ППМ өсөлттэй утгаараа орж ирж байгаа (Давтан ярьж байгаа хяналтын самбар нээж өгөх), 00-ээр эхэлсэн регистрийн дугаартай өрхийг бүртгэж болохгүй үүнийг засварлах. Угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг сүлжээ ороогүй хороодод суурилуулахаар хяналтын дэлгэцэд дохио өгдөггүй тул яаралтай 2025 оны 06, 07 дугаар сард багтааж сүлжээнд оруулахаар шийдвэрлэсэн.



*Зураг 30 ППМ утгаараа орж ирж байгаа дэлгэрэнгүй*

*Арга хэмжээ 2.3.9 Зөв галлагааны горим танилцуулах, зөвлөгөө өгөх судалгаа мэдээлэл авах, угаарын хийн мэдрэгчийг ашиглалтад хяналт тавих сургалтыг 7 дүүргийн*

*хороодын хэсгийн ахлагчид, засварчид болон сайн дурын ажилтан, иргэдэд зохион байгуулж, сэрэмжлүүлэг мэдээллийг түгээх.*

Нийслэлийн Онцгой байдлын газартай хамран 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 17-ны өдрийг дуустал "Сэргийлье-Хамгаалъя" аяны хүрээнд Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Баянгол, Хан-Уул, Баянзүрх дүүргийн 400 гаруй хэсгийн ахлагч нарт угаарын хий мэдрэгч төхөөрөмжийн зөв ажиллагааны горим, яндан зуухны бүрэн бүтэн байдлыг шалгах, угаарын хий гэж юу болох түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх сургалт хийж, сэрэмжлүүлэх материал тарааж, мэдээлэл хүргэн ажилласан.



*Зураг 31 "Сэргийлье-Хамгаалъя" аян*

*Арга хэмжээ 2.3.9 Гэр хорооллын өрхүүдийг угаарын хийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор мэдрэгч төхөөрөмжөөр бүрэн хангаж, бүртгэл мэдээллийг шинэчилж, ашиглалтад хяналт тавих, шаардлагатай засвар үйлчилгээ, заавар зөвлөмжийг хэрэгжүүлэн эрсдэлийн бүлэгт хяналт тавих, иргэд болон сурагчдад сургалт зохион байгуулах.*

Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд 147906 утаарын хий мэдрэгч төхөөрөмжийг суурилуулж, Дэлгэцийн операторууд 24 цагаар хянаж, ППМ 100 болон түүнээс дээш заасан айл өрхүүдтэй цаг алдалгүй холбогдож урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж өгөх, шаардлагатай тохиолдолд шуурхай багийг явуулж шалтгаан нөхцөлийг нь тодруулж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна. 2025 оны 01дүгээр сарын 01-нээс 11 дүгээр сарын 23-ны хооронд хяналтын дэлгэцэд ППМ өссөн 81384 дуудлага мэдээлэл ирсний дагуу 5019 дуудлага мэдээлэл дээр гэрээт хяналтын ажилтнууд газар дээр нь очиж урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж нийт 162768 хүний амь насыг хамгаалж ажилласан байна. Мөн 2024 оны ППМ өссөн дуудлага 13593 өрхийн 40779 хүний амь насыг эрсдэлээс хамгаалж, яаралтай тохиолдолд 718 гэрээт хяналтын ажилтан явуулж ажилласан байна. Өмнө онтой харьцуулахад нэмэлтээр 2025 онд 112 мянган утаарын хий мэдрэгч төхөөрөмж суурилуулсантай холбоотой утаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлсэн хүний тоо 3 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2025 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс 12 дугаар сарын 14-ний өдрийг хүртэл "Интелигент технологи" ХХК-тай хамтран Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Чингэлтэй дүүргийн 12, 17,19,24-дүгээр хороо, Сүхбаатар дүүргийн 18, 19, 20 дугаар хороо, Баянзүрх дүүргийн 5, 32, 24, 34, 35, 20, 33 дугаар хороо нийт 15 хороодод утаарын хий мэдрэгч төхөөрөмжийн сүлжээг шалгаж, хяналт тавин ажилласан. Шинээр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо ЗДТГ-ын байранд болон хүй долоон худаг, Ерөнхий боловсролын 121-р сургуульд утаар мэдрэгч төхөөрөмжийн сүлжээний антен суурилуулсан.

Сүхбаатар дүүргийн 19, 20 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн 19, 24 дүгээр хороонд сүлжээний антеныг бүрэн суурилуулж дууссан. Нэмэлтээр 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс 11 дүгээр сарын 25-ний өдрийн байдлаар Баянзүрх дүүргийн 33-р хороо шар хоолой, 20-р хороо Могойтын дэнж, Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо Хонхор, Баянзүрх дүүргийн 28-р хороонд, Сонгинохайрхан дүүрэг 32-р хороо Хүй долоо худаг зэрэг газруудад сүлжээний 5 антен шинээр суурилуулсан байна. Цаашид Хан-Уул, Баянзүрх дүүргийн сүлжээ ороогүй хэсгүүдэд нэмэлтээр сүлжээний антен суурилуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна



*Зураг 32 сүлжээний антен суурилуулсан*

*Арга хэмжээ 2.3.10 Агаарын бохирдлыг бууруулах, утаарын хийн хордлогоос сэргийлэх чиглэлээр гаргаж буй төрийн бодлого, захирамжуудын хэрэгжилтийг хангах, Нийслэл, дүүрэг, онцгой байдал, цагдаа, бусад байгууллагуудтай хамтран ажиллах.*

Нийслэлийн Онцгой комиссын даргын 2024 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн Шуурхай штаб байгуулах тухай 05 дугаар тушаалын хүрээнд Улаанбаатар хотын хяналтын постууд дээр 24 цагаар Улаанбаатар хотод нэвтэрч буй түүхий нүүрсэнд хяналт, бүртгэл хийх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан. Үүнд 28 хүний бүрэлдэхүүнтэй 24/72 цагаар дараах хяналтын постод хяналт шалгалт хийж ажиллаа. Хяналт шалгалтын хүрээнд: Нийт 4039 тээврийн хэрэгслээр дараах түүхий нүүрс тээвэрлэгдсэн байна. Үүнд нийт түүхий нүүрс орж ирсэн хэмжээ-137925тонн 612кг, үүнээс дамжин өнгөрсөн 93728тонн 2865кг, Улаанбаатар хотод орж ирсэн 60547тонн 655кг байна. Мөн хяналт шалгалт хийж ажиллах хугацаанд нийт 8 сайжруулсан шахмал түлш, хагас коксон түлш тээвэрлэсэн зөрчлийг илрүүлж 8 тонн 350кг түлшийг хураах авч зөрчлийг илрүүлсэн байна.

Улаанбаатар хот руу нэвтэрч буй түүхий нүүрсний бүртгэл 2025.01.01-2025.04.15-ныг хүртэлх

| № | Он.сар.өдөр | Постын нэр | Нийт орж ирсэн түүхий нүүрсний хэмжээ тн/кг | Үүнээс | | Илрүүлсэн шахмал түлшний хэмжээ тн/кг | Шахмал түлш тээвэрлэсэн зөрчлийн тоо | Тээврийн хэрэгслийн тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Дамжин өнгөрсөн /кг/тн | УБ хотод орж ирсэн /кг/тн | | | |
| 1 | 2025.01.01-2025.04.15 | Өлийт | 15618.972 | 7421.772 | 8197.2 | 0 | 0 | 567 |
| 2 | 2025.01.01-2025.04.15 | Таван толгой | 18892.782 | 7442.622 | 11450.16 | 0 | 0 | 725 |
| 3 | 2025.01.01-2025.04.15 | Баруун туруу | 7444.93 | 5836.77 | 1608.16 | 0 | 4 | 190 |
| 4 | 2025.01.01-2025.04.15 | Эмээлт | 5501.13 | 4513.63 | 987.5 | 5тн750 кг | | 207 |
| 5 | 2025.01.01-2025.04.15 | Городок | 44060.65 | 25908.695 | 34502.285 | 0 | 0 | 1690 |
| 6 | 2025.01.01-2025.04.15 | Гунт | - | - | - | 9тн275кг | 3 | - |
| 7 | 2025.01.01-2025.04.15 | 4-р зөрлөг | 46407.1475 | 42604.7975 | 3802.35 | 1тн250кг | 1 | 660 |
| Нийт | | | **137925.612** | **93728.2865** | **60547.655** | **8 тн350кг** | **8** | **4039** |

*Хүснэгт 3 Түүхий нүүрсний бүртгэл*

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/1175 дугаар захирамжаар 5,000 айл өрхийг шингэрүүлсэн шатдаг хийн халаалтад шилжүүлэхэд нийлүүлэгчийг холбогдох хуулийн хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, гэрээ байгуулах эрхийг "Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв" ОНӨААТҮГ-т үүрэг болгосон.

Техникийн тодорхойлолтын дүгнэлтээр Оросын Холбооны Улсын "Уст-Кутский хий боловсруулах үйлдвэр" ХХК техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан.

Техникийн тодорхойлолтод тусгагдсан шаардлагыг бүрэн хангасан Оросын Холбооны Улсын "Уст-Кутский хий боловсруулах үйлдвэр" ХХК-тай шингэрүүлсэн хий нийлүүлэх гэрээг байгуулсан.

Гэрээг байгуулах хэлэлцээрийг эцэслэн хэд хэдэн нөхцөлийг талууд харилцан тохиролцож, 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан.

2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Оросын Холбооны Улсын "Уст-Кутский хий боловсруулах үйлдвэр" ХХК-руу эхний 300 тонн шингэрүүлсэн шатдаг хий худалдан авах захиалга хийсэн. Захиалгын дагуу 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Сэлэнгэ аймгийн Сүхбаатар өртөөгөөр 300 тонн шингэрүүлсэн шатдаг хий хил давж ирсэн. 12 дугаар сарын 10-ны өдөр Толгойт өртөөнд 9 вагон шингэрүүлсэн шатдаг хийг Улаанбаатар Төмөр замын Толгойт өртөөнд "Таван толгой түлш" ХХК-ийн гэрээт агуулах Гор газ ХХК-ийн агуулахад хүлээн авсан.




*Зураг 33 Толгойт өртөө*

## ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД

**Зорилт 1** . Байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй явуулах арга хэмжээний хүрээнд

*Арга хэмжээ 3.1.1. Байгууллагын үйл ажиллагаанд хамаарах хууль, дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлтийг судлан танилцуулах*

Тайлант хугацаанд үйлдвэрийн газрын А, Б тушаал, шийдвэрүүдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу нийцэж буй эсэхийг шалган ажиллав. Мөн үйлдвэрийн газрын хууль хэрэгжилтийн тайланг 2025 оны 09 дүгээр сарын 25 болон 11 дүгээр сарын 17-ны өдрүүдэд нийт хоёр удаа бүртгэн боловсруулж, тайлагнаж ажилласан.


БАТЛАВ.
"ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ"
ОНӨААТҮГ-ын ДАРГА Б.БАТТУЛГА

"ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ" ОНӨААТҮГ-ын 2025 ОНЫ IV УЛИРЛЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025.11.17 Улаанбаатар хот

I. Тайлангийн зорилго

Энэхүү тайлан нь "Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв" ОНӨААТҮГ-ын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын дүрэмд заасан үндсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах санал гаргах зорилготой болно.

II. Хамаарах хууль, эрх зүйн баримт бичиг

1. Монгол Улсын Агаарын тухай хууль
2. Хөдөлмөрийн тухай хууль
3. Байгаль орчныг хамгаалах тухай хууль
4. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
5. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
6. Нийслэлийн Засаг даргын захирамж, шийдвэрүүд
7. Байгууллагын Дүрэм, Дотоод журам, Жилийн төлөвлөгөө

III. Үндсэн чиг үүргийн хэрэгжилт

*Зураг 34 Хууль хэрэгжилтийн тайлан*




*Зураг 35 Тойм*

*Арга хэмжээ 3.1.1.* Орон нутгийн өмчит аж ахуйг тооцоот *үйлдвэрийн газрын эрх зүйн орчныг хангасан дотоод журам, гэрээний загваруудыг шинэчлэх*

Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд мөрдөгдөх дотоод журам, гэрээний загваруудыг холбогдох хууль тогтоомж, дээд шатны бодлогын баримт бичиг, байгууллагын бүтэц, чиг үүргийн өөрчлөлттэй уялдуулан хянан үзэж, хэрэгжилтгүй, давхардсан болон тодорхой бус зохицуулалтыг засварлан шинэчлэн боловсруулсан.

Үүнд:

- ✓ Үйлдвэрийн газрын дотоод журам
- ✓ Ажил албан үүргийг түр орлох, хавсран гүйцэтгэх, ажил хүлээлцэх журам
- ✓ Даргын зөвлөлийн журам
- ✓ Дэлгэцийн операторын ажлын байранд мөрдөх журам
- ✓ Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам
- ✓ Ёс зүйн дүрэм
- ✓ Цаг ашиглалтын журам
- ✓ Мэдээллийн аюулгүй байдлын дотоод журам
- ✓ Өмч хамгаалах байнгын зөвлөлийн журам

Нийт 10 төрлийн баримт бичгийг шинэчлэн боловсруулж, удирдлагын шийдвэрээр батлуулан хэрэгжилтийг хангах, биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулсан.

Үүний үр дүнд байгууллагын дотоод удирдлага, зохион байгуулалт, хариуцлагын тогтолцоо сайжирч, хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах нөхцөл бүрдсэн.



Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын даргын [illegible] оны [illegible] дугаар сарын [illegible]-ны өдрийн [illegible] дугаар тушаалын хавсралт

"ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ"
ОНӨААТҮГ-ЫН ХӨДӨЛМӨРИЙН ДОТООД ЖУРАМ

ЭРХЭМ ЗОРИЛГО

"Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв" ОНӨААТҮГ (цаашид "Үйлдвэрийн газар" гэх) нь Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, утааны хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зорилгоор хатуу болон хийн түлш хэрэглэгч айл өрхүүдийн хэрэглээнд хяналт тавих, пийшин, яндан, зуухны битүүмжийг шалгах, засвар үйлчилгээ үзүүлэх, зөв галлагааны горим болон утааны хийнээс сэргийлэх санамж, зөвлөмжийг түгээх, судалгаа мэдээлэл нэгтгэх, сургалт зохион байгуулах, утааны хий мэдрэх төхөөрөмжийн ашиглалтад хяналт тавих, хяналтын системээр тасралтгүй хянах замаар эрсдэлээс урьдчилан сэргийлж, нийтийн аюулгүй, эрүүл орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тууштай хэрэгжүүлнэ.

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1."Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв" ОНӨААТҮГ-ын Хөдөлмөрийн дотоод журам нь /цаашид "дотоод журам" гэх/ Үйлдвэрийн газрын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, стандартын дагуу гүйцэтгэх, хөдөлмөр, зохион байгуулалтыг оновчтой болгох, түүнд мөрдөгдөх эрх зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, хамрах хүрээний зохистой тэнцвэрт байдлыг бататгах, ажилтнуудын нийгмийн асуудлыг зохих түвшинд шийдвэрлэн, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, үндсэн үүрэг, ажлыг хангахад оршино.

1.1.2.Дотоод журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг Газрын даргын эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэж, газрын нийт ажилтнууд үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлнэ.

1.1.3.Хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр Хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан, ажил олгогчийн хооронд үүссэн асуудлыг Хөдөлмөрийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль, тогтоомж, хамтын гэрээ, хэлэлцээрийг үндэслэн энэ журмын дагуу шийдвэрлэнэ.

1.1.4.Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтэд хөдөлмөрийн харилцаанд оролцогч талууд хяналт тавина.

1.1.5.Цалин хөлс, урамшуулал олгох зэрэг хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулна.

1.2. Үйлдвэрийн газрын даргын бүрэн эрх

1.2.1.Үйлдвэрийн газрын дарга нь холбогдох хууль, эрх зүйн актыг баримтлан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1.2.2.Үйлдвэрийн газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, шийдвэр гаргах;

1.2.3.Ажилтныг ажилд томилох, чөлөөлөх, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах;

1.2.4.Үйлдвэрийн газрын төсөв, санхүүгийн зарцуулалтад хяналт тавих, батлах;

1.2.5.Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс гэрээ хэлцэл байгуулах, эрх бүхий

*Зураг 36 Дотоод журам*



"ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ" ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 14 өдөр Дугаар А/44 Улаанбаатар хот

Хөдөлмөрийн дотоод журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын "Дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Хөдөлмөрийн дотоод журам"-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж, мөрдлөг болгон ажиллахыг нийт ажилтнуудад үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Ц.Болормаад үүрэг болгосугай.

ДАРГА Б.БАТТУЛГА

*Зураг 37 Хөдөлмөрийн дотоод журам*

**Зорилт 2**. Гэрээний эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, хэрэгжилтэд хяналт тавих зорилтын хүрээнд

*Арга хэмжээ 3.2.1. Гэрээ байгуулах, хянах, хэрэгжилтэд хяналт тавих процессыг боловсронгуй болгох*

Тайлант хугацаанд үйлдвэрийн газрын хэмжээнд байгуулсан нийт 67 гэрээний төслийг боловсруулах, хууль зүйн хяналт хийх, байгуулж баталгаажуулах үйл ажиллагаанд оролцож, гэрээ бүрийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажилласан.Үүнд:

Ажлын гүйцэтгэх гэрээ: 36

Сургалтын гэрээ: 5

Худалдах, худалдан авах гэрээ: 2

Хамтран ажиллах гэрээ: 17

*Арга хэмжээ 3.2.2. Хэрэглэгчидтэй байгуулах хариуцлагын гэрээний загваруудыг сайжруулах*

Угаарын хий мэдрэгч төхөөрөмжтэй холбоотой гэрээний загварыг холбогдох хууль тогтоомж болон хэрэгжилтийн явцад илэрсэн асуудлуудыг үндэслэн 2 удаа дахин хянан үзэж, эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан сайжруулан шинэчлэн боловсруулсан. Хууль эрх зүйн хүрээнд хэрэгжилтийг хангахдаа эд хариуцагч болон эзэмшүүлэгчийн хариуцлагыг тусгаж өөрсдөөрөө төрийн үйлчилгээг иргэдэд баримт, шаардлагатай материалыг үндэслэн хүргэх үйлчилгээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Дараа нь удирдлагын шийдвэрээр батлуулж, практик хэрэглээнд нэвтрүүлсэн.

Тав.Бусад нөхцөл

5.1.Энэ гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдсэн бөгөөд тал тус бүр нэг хувийг хадгална.

5.2.Энэхүү гэрээний аль нэг заалт нь хүчин төгөлдөр бус байх нь энэхүү гэрээг бүхэлд нь хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл болохгүй.

5.3.Гэрээнд оролцогч талууд өөр хоорондоо зөвшилцөхгүйгээр гэрээгээр хүлээсэн үүргээ хэн нэгэн гуравдагч этгээдэд шилжүүлэх болон гэрээг дангаар цуцлахыг хориглоно.

5.4.Хэрэглэгч оршин суугаа хаягаа өөрчилсөн тохиолдолд 5 хоногийн дотор Эзэмшүүлэгчид албан ёсоор мэдэгдэнэ.

Гэрээ байгуулсан:

Эзэмшүүлэгч:
Хэрэглэгч :

Овог нэр: ..................................... Овог
нэр: .....................................

Холбоо барих утас: 70119410 Холбоо
барих утас: ...................
70004454
Хаяг:Баянгол дүүрэг 9 дүгээр
Төхөөрөмжийн код.......................
хороо 25 дугаар байр Гэрийн
хаяг:...............................

Гарын үсэг: ..................................... Гарын
үсэг: ..................................

*Зураг 38 Гэрээний загвар*

## УГААРЫН ХИЙ МЭДРЭГЧ ТӨХӨӨРӨМЖ АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

.....оны...дугаар сарын...өдөр Дугаар....

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас "ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ" ОНӨААТҮГ ыг төлөөлөн..........................албан тушаалтай...................овогтой....................... (цаашид "Эзэмшүүлэгч" гэх), нөгөө талаас__________ хаягт оршин суух РД:....................иргэн ______________овогтой______________(цаашид "Хэрэглэгч" гэх) бид энэхүү гэрээг байгуулав.

Нэг.Нийтлэг үндэслэл

Энэхүү гэрээгээр Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдийг галлагааны улиралд угаарын хийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тараасан угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг иргэн болон төрийн байгууллагын нэгж болох хороодод хэрхэн түгээх, ашиглах талаарх ажиллагааг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.1.Энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжоор зохицуулна.

1.2.Энэхүү гэрээний зорилго нь гэр хорооллын айл өрхийг угаарын хийн эрсдэлээс сэргийлэх, угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглуулахад оршино.

1.3.Угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг хэрэглэгч нь угаарын хий хордлогоос урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглах үүрэгтэй.

Хоёр.Эзэмшүүлэгчийн эрх, үүрэг

2.1.Эзэмшүүлэгч тухайн төхөөрөмжийг энэ гэрээний заалт ёсоор ашиглаж байгаа эсэхийг урьдчилан мэдэгдэж, Хэрэглэгчийн зөвшөөрөлтэйгөөр шалгаж үзэх эрхтэй.

2.2.Эзэмшүүлэгчийн үүрэг:

а)Угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг хэвийн ажиллагаатай ашиглах нөхцөлийг хангах үүднээс төхөөрөмжийн техникийн ашиглалтын дүрэм, зааварчилгааг эзэмшигч талд танилцуулах, шаардлагатай тохиолдолд ашиглаж буй байршилд очиж холбогдох ажилтнаар дамжуулан заавар зөвлөмж өгөх;

б) Угаарын хий мэдрэгч төхөөрөмжийг зөв ашиглах талаар мэдээлэл, зөвлөгөө өгч дэмжлэг үзүүлэх

*Зураг 39 Гэрээний загвар*

*Арга хэмжээ 3.2.3 Гэрээ зөрчигдсөн тохиолдолд хууль, гэрээний дагуу арга хэмжээ авах эрх зүйн зохицуулалтыг судлан гэрээнд оруулах, батлуулах, хэрэгжүүлэх*

Тайлант хугацаанд байгууллагын хэмжээнд хэрэгжиж буй гэрээний хэрэгжилтийн явцад үүссэн зөрчил, маргааны шалтгаан, нөхцөлийг холбогдох хууль тогтоомж, гэрээний нөхцөлүүдтэй уялдуулан нарийвчлан судалж, зөрчил үүсэх эрсдэлийг бууруулах, хариуцлагын тогтолцоог тодорхой болгох зорилгоор эрх зүйн зохицуулалтыг боловсруулан гэрээний загваруудад тусган шинэчилсэн.

Судалгааны явцад гэрээг дүгнэх акт үйлдэх үед ажлыг хариуцаж хүлээн авах алба, хэлтэс, албан тушаалтны эрх, үүрэг тодорхойгүй байснаас үүдэн гэрээний биелэлтийг дүгнэхэд хүндрэл үүсэх, улмаар маргаан, зөрчил гарах нөхцөл бүрдэж байгааг тогтоосон.

Энэхүү асуудлыг шийдвэрлэх зорилгоор:

Гэрээний хэрэгжилт бүрд холбогдох алба, хэлтсийн оролцоог заавал хангах,

Ажлын хариуцлагыг тодорхой болгосон ажлыг хүлээж авах комисс байгуулах,

Гэрээ дүгнэх акт үйлдэх журам, хариуцлагын зохицуулалтыг тодорхой тусгасан

тушаалын төслийг боловсруулж, удирдлагаар баталгаажуулан, холбогдох албан хаагчдад танилцуулж хэрэгжилтийг хангуулсан.

Мөн дээрх зохицуулалтыг тусгасан гэрээний шинэчилсэн загваруудыг мөрдлөг болгон ашиглаж эхэлснээр гэрээний хэрэгжилтийг дүгнэх үйл явц нэг мөр ойлгомжтой болж, хариуцлага тодорхой, маргаан үүсэх эрсдэл буурсан.

Үр дүн:

-Гэрээ бүрийн биелэлтийг хангах зохион байгуулалт сайжирсан
-Зөрчил, маргааны тоо буурч, урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдсэн
-Гэрээний хэрэгжилт, хяналт-шинжилгээ ил тод, тогтвортой болсон
-Алба, хэлтсүүдийн уялдаа холбоо, хариуцлага дээшилсэн

**Зорилт 3.** Удирдлага болон УЗ-ийн үйл ажиллагааг дэмжих, зохион байгуулалтын ажлын хүрээнд

Удирдах зөвлөлийн анхдугаар хурал 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан. Удирдах зөвлөлийн нийт 5 гишүүнээс Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөц, хөгжлийн хэлтсийн дарга Ц.Маргад-Эрдэнэ нь албан үүргээсээ чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор Удирдах зөвлөл 4 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр, хуульд заасан ирцийн шаардлагыг хангасан нөхцөлд, батлагдсан төлөвлөгөөний дагуу хуралдаж, хурлаас гарсан шийдвэр, тогтоолын төслүүдэд хууль зүйн дүгнэлт боловсруулан, холбогдох бичиг баримтын найруулга, боловсруулалтыг хийж гүйцэтгэсэн.



*Зураг 40 УЗ-ын хурал*

*Арга хэмжээ 3.3.1 УЗ-ийн хурлын шийдвэр, тогтоолын төсөлд хууль зүйн дүгнэлт гаргах, бичиг баримт боловсруулалт хийх*

Удирдах зөвлөлийн нарийн бичгийн чиг үүргийн хүрээнд 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан Удирдах зөвлөлийн анхдугаар хурлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, Удирдах зөвлөлийн 5 гишүүнээс нэг гишүүн албан үүргээсээ чөлөөлөгдсөнтэй холбогдуулан 4 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хуралдааныг хуульд нийцүүлэн явуулсан. Хурлын ирц, хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийг бүрэн баримтжуулж, хурлын тэмдэглэл, тогтоол, шийдвэрийг холбогдох албан тушаалтнуудад танилцуулан, архив, бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж ажилласан.



*Зураг 41 УЗ-ын хурал*

**Зорилт 4.** Хэлтэс, нэгжийн уялдаа холбоог сайжруулах, хууль зүйн зөвлөгөө тогтмол өгөх зорилтын хүрээнд

*Арга хэмжээ 3.4.1 Хэлтэс, нэгжүүдэд хууль зүйн зөвлөгөө, заавар чиглэл тогтмол өгөх, гарч буй аливаа шийдвэрүүдийг хууль эрх зүйн үндэслэлтэй гаргахад дэмжлэг үзүүлэх*

Хэлтэс, нэгжүүдэд хууль зүйн зөвлөгөө, заавар, чиглэл тогтмол өгч, гарч буй аливаа шийдвэр, тогтоол, гэрээ болон бусад баримт бичгийг хууль эрх зүйн үндэслэлтэйгээр боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэв.

*Арга хэмжээ 3.4.2 Шинээр хэрэгжих төсөл, чиг үүрэгтэй холбоотой хууль эрх зүйг судлах, мэдээллээр хангах, гарах эрсдэлийг урьдчилан бууруулах*

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн "Ажил гүйцэтгэх тухай" А/1175 дугаар захирамжийн хэрэгжилтийн хүрээнд холбогдох хууль, тогтоомжийг судалж, хэрэгжилтийг хангаж ажиллав.
Үйлдвэрийн газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/23 дугаар тушаалаар баталсан ажлын хэсэгт томилогдон ажиллаж, ажлын хэсгийн шийдвэрийн дагуу шалгарсан нэг аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан.

Мөн 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр байгуулагдсан ажлын хэсгийн шийдвэрийн дагуу холбогдох гэрээнүүдийг байгуулж ажиллав. Тус ажлын хэсэг нь худалдах, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, шийдвэрийн дагуу нийт 5 аж ахуйн нэгжтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажилласан.





**Зорилт 5.** Байгууллагын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд

*Арга хэмжээ 3.5.1 Байгууллагын ажилтнуудын хөдөлмөрийн гэрээ хүний нөөцийн бүрдүүлэлтийн мэдээг улирал тутамд гаргаж танилцуулах*

Тус байгууллагын 2025 оны байгууллагын бүтэц, орон тооны хүрээнд үндсэн нэгжүүдэд дараах тооны ажилтнууд ажиллаж байна:

- ✓ Удирдах түвшинд-6
- ✓ Захиргаа, удирдлагын хэлтэс-18
- ✓ Мэдээлэл технологийн хэлтэс-23
- ✓ Засвар үйлчилгээний хэлтэс-22
- ✓ Санхүүгийн албанд-4 ажилтан тус тус ажиллаж байна.

Түүнчлэн, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор нийслэлийн 7 дүүргийн 700 орчим гэрээт хяналтын ажилтантай (давхардсан тоогоор) хөдөлмөрийн гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын даргын 2025 оны [illegible] дугаар сарын 23 өдрийн [illegible] дугаар тушаалын 4-р хавсралт

| | | | |
|---|---|---|---|
| ОНӨААТҮГ | Баримт бичгийн нэр: ХҮНИЙ НӨӨЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ БҮРДҮҮЛЭЛТ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТУХАЙ ЖУРАМ | | |
| | Журмын дугаар 03 Ж-ЗУХ/ | Хувилбар 1 | |
| | Хуудасны тоо 17 | Бүлгийн тоо 7 | |
| | Баталсан тушаалын дугаар, огноо Үйлдвэрийн газрын даргын [illegible] тоот тушаалын хавсралт № 03 | | |
| Хянасан | Гарын үсэг | Овог нэр | Огноо |
| Захиргаа удирдлагын хэлтсийн дарга | | Ц.Болормаа | 2025.09.23 |
| Журамд санал өгсөн мэдээлэл | Хэлтэс, албаны удирдлагууд саналын хуудсыг хавсралтаас харах | | |
| Боловсруулсан | Гарын үсэг | Овог нэр | Огноо |
| Хүний нөөцийн мэргэжилтэн | З.Оюунтуяа | З.Оюунтуяа | 2025.09.23 |
| Эх хувь | Хяналттай хувь | Хуулбар үнэн | Хүчинтэй хувь |
| Нэмэлт өөрчлөлт оруулсан мэдээлэл | Шинээр боловсруулав 2025.09.23 | | |

*Зураг 42 Хөдөлмөрийн гэрээ*




*Зураг 43 Ажлын байрны тодорхойлолт*

*Арга хэмжээ 3.5.2 Хүний нөөцийн бүрдүүлэлт, мэдээллийн сангийн бааз үүсгэх, тайлан мэдээг улирал тутам гарган танилцуулах*

2025 оны батлагдсан бүтэц, орон тооны дагуу үндсэн 74, гэрээт хяналтын 500 орон тоотой ажиллаж байна. Одоогийн байдлаар сул байгаа орон тоо: Удирдлагын түвшин-1

- ✓ Захиргаа, удирдлагын хэлтэс-2
- ✓ Мэдээлэл технологийн хэлтэс-1
- ✓ Засвар үйлчилгээний хэлтэс-2
- ✓ Гэрээт хяналтын ажилтан-65

Нийт сул орон тоо-71

Сул орон тооны зарыг үйлдвэрийн газрын цахим сайтад байршуулж бүрдүүлэлтийг

нөхөн ажиллаж байна. Сул орон тооны зард хөдөлмөрийн сул зах зээлээс 5 иргэний хүсэлтийг хүлээн авч ажилласан.



ДАРГА Б.БАТТУЛГА



ДАРГА Б.БАТТУЛГА

*Зураг 44 Хүний нөөцийн бодлогийн баримт*

*Зураг 45 Журам*

*Арга хэмжээ 3.5.3 Байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсруулах, сайжруулах*

Хүний нөөцийн чиглэлээр дараах журам, баримт бичгүүдийг боловсруулан батлуулж ажиллаа. Тайлант хугацаанд үйлдвэрийн газрын А тушаал-61, Б тушаал-170 шийдвэрүүдийг холбогдох хууль эрх зүйн хүрээнд шинэчлэн боловсруулан мөрдөн ажиллаж байна. Үүнд:

Ажилд авах тушаал-85

Ажлаас чөлөөлөгдөх тушаал-34

Буцалтгүй тусламж үзүүлэх-3

Шинэ хүүхдийн чөлөө олгох-2

Сахилгын шийтгэл ногдуулах-3

Урамшуулал олгох-2

Шилжин ажиллах-5

Бусад-40

Байгууллагын хүний нөөцийн бодлого, стратегийг хэрэгжүүлэх, ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийг хангах чиглэлд дараах бичиг баримтуудыг боловсруулан мөрдөн хэрэгжилтийг төрийн захиргааны шийдвэрийн дагуу хэрэгжилтийг мөрдөн ажилласан.

Хөдөлмөрийн гэрээ, нууцын гэрээ зэргийг ажилтнуудад ажлын чиг үүрэг мэдээллийн аюулгүй байдал зэргийг хангаж байгуулан ажиллаж байна.



*Зураг 45 Нууц хадгалах гэрээ*

Хүний нөөцийг бодлогын бичиг баримт боловсруулсан байдал

Албан тушаалын тодорхойлолт -23

Хүний нөөцийн бодлого, стратеги

Ажилтны гүйцэтгэлийг үнэлэх, үр дүнгийн урамшууллын журам

Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам зэргийг боловсруулан үйл ажиллагаанд хэрэгжүүлэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэн ажиллаж байна. Нийслэл хотын 7 дүүргийн төрийн байгууллагатай хамтран ажиллах хүчний сонгон шалгаруулалтыг Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг хууль зэргийг үндэслэн зохион байгуулан ажиллах хүчний нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна.





*Зураг 46 Хүний нөөцийн төлөвлөлт*

**Зорилт 6.**Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, тогтоомж, заавар журмуудын хэрэгжилтэд хяналт тавих зорилтын хүрээнд

*Арга хэмжээ 3.6.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм журам, стандартыг мөрдөх, хэрэгжилтэд хяналт тавих, тасралтгүй сайжруулалт хийж, аюулгүй, эрүүл ажлын байр бүрдүүлэх.*

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагын хэмжээнд тогтмол хяналт шалгалт зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгах арга хэмжээг авч ажилласан. Ажлын байрны эрсдэлийн үнэлгээг шинэчлэн хийж, аюулгүй ажиллагааны заавар, журмуудыг мөрдүүлэн ажилласнаар осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Ажилтнуудын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг сайжруулах хүрээнд хөдөлмөр хамгааллын сургалт, зааварчилгааг тогтмол зохион байгуулж, хувийн хамгаалах хэрэгслийн хангалтыг сайжруулан, тэдгээрийн зөв хэрэглээнд хяналт тавьж ажилласан. Үүний үр дүнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тасралтгүй сайжруулалтыг хангаж, аюулгүй, эрүүл ажлын байр бүрдүүлэхэд тодорхой ахиц гарсан.

*Арга хэмжээ 3.6.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм журмуудыг боловсруулах, шинэчлэх хэрэгжүүлэх, хяналт тавих*

Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуйн (ХАБЭА) хүрээнд дараах үндсэн журмуудыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаа. Үүнд:

- ✓ Үйлдвэрийн ослыг судлан бүртгэх журам
- ✓ ХАБЭА-н зөвлөлийн журам
- ✓ Хор саармагжуулах нэмэлт бүтээгдэхүүн (хүнс) олгох журам
- ✓ Эрүүл мэндийн үзлэгт хамруулах журам
- ✓ Ажлын болон нэг бүрийн хамгаалах хувцас олгох журам

*Арга хэмжээ 3.6.3 Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах, хэрэглэж хэвшүүлэх*

Засвар үйлчилгээний хэлтсийн ажилчдыг зуны болон өвлийн гутал, ажлын хувцсаар, Захиргаа удирдлага болон мэдээлэл технологийн хэлтэс, Гэрээт хяналтын ажилчдыг ажлын дүрэмт хувцсаар хангасан. Нохой, муур үргээгч төхөөрөмжийг Хяналтын ажилчид болон Засварчин ашиглаж аливаа эрсдэлээс өөрийгөө хамгаалах боломжоор хангаж ажиллаж байна. Засварчдыг бээлий, нарийн тоосонцроос хамгаалах хамгаалалтын шүүлтүүртэй маск, өндрөөс унахаас хамгаалсан хамгаалах бүсээр хангасан.

*Арга хэмжээ 3.6.4* MNS4969:2000 стандартын дагуу аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгөх, дадал хэвшилд сургах, хянах




*Зураг 47 Хангалт*

Ажлын онцлогт нийцсэн зааварчилгааг боловсруулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өдөр тутмын зааварчилгааг тогтмол өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн цаг үеийн нөхцөл байдалд тохируулан давтан болон анхан шатны зааварчилгааг зохион байгуулж, тайлант хугацаанд 8 удаагийн давтан, 12 удаагийн анхан шатны зааварчилгааг хүргэн ажиллав.



*Зураг 48 Хөдөлмөр аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгаа*

*Арга хэмжээ 3.6.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах*

Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөг Улирал болон жилээр боловсруулан батлуулж төлөвлөгөөний дагуу сар бүр хийсэн ажлаа Үйлдвэрийн газрын даргын зөвлөлд тайлагнаж ажиллаж байна.

*Арга хэмжээ 3.6.6 Өндөр эрсдэлтэй ажлын байранд ажиллаж буй ажилтнуудыг гэнэтийн ослын даатгалд хамруулах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах*

Өндөр эрсдэлтэй ажлын байранд ажиллаж буй Засварчид (22 ажилтан) болон Гэрээт хяналтын ажилтан (500 ажилтан) нийт 522 ажилтныг "МИГ Даатгал" ХХК-тай гэрээ байгуулан, гэнэтийн ослын даатгалд бүрэн хамруулсан.

2025 онд ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ нийт 7 хяналтын ажилтан (халтирч унах, нохойд хазуулах, иргэдэд зодуулах) зэрэг ослын тохиолдлуудад өртсөн ослын акт тогтоон даатгалын компаниар дамжуулан тэдгээр ажилтнуудын хохирлыг бүрэн барагдуулж, шаардлагатай эмчилгээ, сувилгааг хийлгэн ажиллаа.





*Зураг 49 Эмчилгээ*

*Арга хэмжээ 3.6.7 Үйлдвэрийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх комисс томилох, ослын тайлан мэдээг цаг тухай бүх гаргах*

Үйлдвэрийн даргын тушаалаар Үйлдвэрийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх Ажлын хэсгийг байгуулж, тус хэсгийн ажиллах журам болон чиг үүргийг боловсруулан батлуулсан.

Тайлант хугацаанд нийт 7 осол бүртгэгдсэн бөгөөд осол бүрд журмын дагуу нарийвчилсан судалгааг хийж, ослыг актыг судлан бүрдүүлж холбогдох арга хэмжээг авч ажилласан.



*Зураг 50 Осолд орсон ажилчид*

*Арга хэмжээ 3.6.8* Галын аюулаас урьдчилан сэргийлэх галын булан, аранз, эмийн сангийн бэлэн байдлыг хангах

Гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалтын малгай-10, аранз-10 ширхгийг бүрэн цэнэглэн бэлдэж бэлэн байдлыг хангуулсан. Мөн 7 дүүрэг, төв оффист эмийн сан, галын хор, галын сараа бэлдэн гамшгийн үеийн бэлэн байдлыг хангуулан ажиллаж байна.



*Зураг 51 Галын хор*

*Арга хэмжээ 3.6.9* Хортой нөхцөлд ажиллаж буй ажилтнуудад хор саармагжуулах хүнсний нэмэлт бүтээгдэхүүн олгох, хянах, тайлагнах.

Засварчин-20, инженер-3, оператор-20, үйлчлэгч-1 нийт 44 ажилтанд хор саармагжуулах хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг өдөр бүр ажлын байран дээр олгон хэвшүүлсэн. Мөн бохирдол ихтэй ажлын байранд ажилладаг ажилтнуудыг усанд орох, хувцас угаах өрөөг тохижуулж, ажиллах таатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн.



*Зураг 52 ажилтнуудад хор саармагжуулах хүнсний нэмэлт бүтээгдэхүүн олгох*

**Зорилт 7.** Гүйцэтгэлийн төлөвлөгөө түүнийг хянах үнэлэх, тайлагнах, ажлын цаг ашиглалт, бүтээмжийг нэмэгдүүлэн зорилт арга хэмжээний хүрээнд

*Арга хэмжээ 3.7.1* Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг цаг тухай бүр гаргуулж дүгнэх, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, сайжруулах, ажлыг үе шаттай зохион байгуулах.

Байгууллагын гүйцэтгэлийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар зүйлийн 6,7 дугаар хавсралтын дагуу сар бүр хагас жил, бүтэн жилийн төлөвлөгөө тайланг нэгтгэн үр дүнг дүгнэн ажиллаж байна.

Үйлдвэрийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Энэ хүрээнд улирал, хагас жил болон бүтэн жилийн гүйцэтгэлийн тайланг боловсруулж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сар, улирал, хагас бүтэн жилээр 3 хэлтэс, 1 албаны мэргэжилтнүүдээс авч ажлыг дүгнэн ажилласан.

Байгууллагын хэмжээнд 2025 оны 04.15- 12 сарын 15 хүртэлх хугацаанд 8 удаагийн ажлын биелэлтийг хангаж үүний үр дүнд 10,11 дүгээр сард нийт 9 ажилтанд гүйцэтгэлийн урамшууллыг олгосон. Урамшууллыг олгохдоо гүйцэтгэлийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн тайлантай уялдуулж дүгнэсний үндсэн дээр, ажилтны гүйцэтгэлийг үнэлэх, үр дүнгийн урамшууллын журмыг баримтлан ажилласан.

Үүнд:

- Захиргаа удирдлагын хэлтэс -2
- Мэдээлэл технологийн хэлтэс -3
- Засвар үйлчилгээний 5 ажилтны гүйцэтгэлийг үр дүнд урамшуулал олгосон.

*Арга хэмжээ 3.7.2 Хяналтын ажилтнуудын ажлын гүйцэтгэл, давсан зохицуулалт, ажил үүргийн чиглэл дээр дүүрэг хариуцсан мэргэжилтнүүдийг удирдлага, чиг үүргээр хангах*

Нийслэл хотын 7 дүүргийн гэрээт хяналтын ажилтнуудад 4 удаагийн дараах төрлийн сургалт, мэдээлэл, зааварчилгааг өгч ажиллаа.

- Хэрэглэгчтэй харилцах соёл, харилцаа хандлага (харилцааны чиглэл)
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилга, ажлын байрны эрсдэл
- Албан тушаалын тодорхойлолт (чиг үүргийг танилцуулах) тус тус сургалт зөвлөгөө тухай бүр өгсөн.




*Зураг 53 сургалт зөвлөгөө*

**Зорилт 8**. Байгууллагын хэмжээнд гарч буй бичиг баримтыг архив албан хэрэг хөтлөлтийн стандарт шаардлагад нийцүүлэх зорилт арга хэмжээний хүрээнд

*Арга хэмжээ 3.8.1 Үйлдвэрийн газарт ирсэн, явсан албан бичгийн бүртгэл мэдээллийг хийх, өргөдөл гомдол, тушаал шийдвэрийн биелэлтийн тайланг гаргах.ы*

Тайлант хугацаанд 78 ирсэн бичиг бүртгэгдэж, 220 хуудас баримт хүлээн авсан байна. Ирсэн бичгийн 66 нь системээр бүртгэгдсэн, 12 нь байгууллагад шуудангаар ирсэн бөгөөд 17 бичиг хариутай, 61 бичиг хариугүй байна. Хариутай бичгийн 61-ийг хугацаанд нь шийдвэрлэн хаасан.

Мөн 179 явсан бичиг, мэдээлэл илгээснээс 6 нь хариутай, 173 нь хариугүй бөгөөд 1 бичиг хугацаа хэтэрсэн, 4 бичиг шийдвэрлэх шатандаа баримт бичиг бүрдүүлж байна. Мөн чиг үүргийн хүрээнд 11-11 дугаар утсанд ирсэн 9 удаагийн гомдлыг хариуцах ээзнд нь холбож Таван толгой ХХК -д хүргүүлэн шийдвэрлэсэн.

Тайлант хугацаанд албан хаагчдаас нийт 530 өргөдөл, гомдол ирснээс 496 нь ажилд орох, чөлөө хүссэн 11, ажлаас чөлөөлөгдөх 8, хүсэлт гаргах 7, шилжин ажиллах 3, хүүхэд

асрах  чөлөө 2, мөнгөн урамшуулал 2, санал 1, гомдол 11 байна. Гомдлын 4-ийг шийдвэрлэж, 7-г шийдвэрлэх шатанд ажиллаж байна.

*Арга хэмжээ 3.8.2* Үйлдвэрийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах.

Үйлдвэрийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.



*Зураг 54 Төлөвлөгөөний баримт*

*Арга хэмжээ 3.8.3 Алба нэгж, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, ажлын гүйцэтгэл, үр дүнг тухай бүр үнэлэх, тайлагнах*

2025 онд 3 хэлтэс, 1 алба үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж ажилласан бөгөөд ажилтнууд сар бүр, хэлтэс, алба улирал бүр ажлын гүйцэтгэлийн тайланг гарган хагас бүтэн жилээр байгууллагын тайланг гарган гүйцэтгэлийн хэрэгжилтийг хангаж ажилласан.

*Арга хэмжээ 3.8.4 Архивын тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангаж ажиллах*

Байгууллагын 2024-2025 оны галлагааны жилийн 03 дугаар сараас 05 дугаар сард нийслэл хотын 7 дүүргийн хатуу, болон хийн түлш хэрэглэгч айл өрх, албан байгууллагад суурилуулсан "Интеллигент технологи" ХХК-ны угаарын хий мэдрэгч Интум төхөөрөмжийн суурилуулалтын мэдээллийг архив албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу бэлтгэн 461 боть архивын бүрдлийг Нийслэлийн агаар орчны бохирдолтой тэмцэх газар хүлээлгэн өгч мөн өөрийн архиваа бүртгэн архивын сангаа бүрдүүлэн ажиллаж байна.



*Зураг 55 Мэдээллийг архивлах явц*

*Арга хэмжээ 3.8.4 Үйлдвэрийн даргын шуурхай, хурлын тэмдэглэл хөтлөх, шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж Үйлдвэрийн газрын удирдлагад танилцуулж ажиллах*

Байгууллагын чиг үүрэг, хууль эрх зүйн хэрэгжилтийн хүрээнд цаг үеийн шинжтэй шуурхай хурал-8, даргын зөвлөлийн хурал 3, Дотоод хяналтын хурал-2, Удирдах зөвлөлийн хурал-1, нэгжийн хурал 18 удаа тус тус хуралдаж хурлаас гарсан үүрэг даалгаврын биелэлтийг 3 хэлтэс, 1 албанд хүргүүлж биелэлтийг хангуулж ажилласан.

Арга хэмжээ 3.8.5 Үйлдвэрийн даргын шуурхай, хурлын тэмдэглэл хөтлөх, шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж Үйлдвэрийн газрын удирдлагад танилцуулж ажиллах

Цаг үеийн шинжтэй шуурхай хурал-8, даргын зөвлөлийн хурал 3, Дотоод хяналтын хурал-1, Удирдах зөвлөлийн хурал-1, нэгжийн хурал 18 удаа тус тус хуралдаж хурлаас гарсан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажилласан.

*Арга хэмжээ 3.8.6 Edoc.ulaanbaatar.mn программ ашиглалт, ирсэн, явсан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, ажил үүрэгтэй холбоотой албан бичиг боловсруулах, холбогдох байгууллагад тайлан мэдээ цаг тухай бүр гарган хүргүүлэх*

Тайлант хугацаанд 78 ирсэн бичиг бүртгэгдэж, 220 хуудас баримт хүлээн авсан байна. Ирсэн бичгийн 66 нь системээр бүртгэгдсэн, 12 нь байгууллагад шууд ирсэн бөгөөд 17 бичиг хариутай, 61 бичиг хариугүй байна. Хариутай бичгийн 61-ийг хугацаанд нь шийдвэрлэн хаасан.

Мөн 179 явсан бичиг, мэдээлэл илгээснээс 6 нь хариутай, 173 нь хариугүй бөгөөд 1 бичиг хугацаа хэтэрсэн, 4 бичиг шийдвэрлэх шатандаа баримт бичиг бүрдүүлж байна.




*Зураг 56 Шийдвэрлэлтийн мэдээ*

*Арга хэмжээ 3.8.7 Erp.Ulaanbaatar.mn системд ажилтнуудыг бүртгэх, мэдээллийг шинэчлэх*

Удирдлагын -7, Захиргаа удирдлагын -15, Засвар үйлчилгээ -3, Мэдээлэл технологийн хэлтсийн -3, Санхүүгийн 4 тус тус алба хэлтсийн ажилтнуудыг бүртгэсэн. Төрийн байгууллагын нэгдсэн системд бүртгүүлэн ажлын чиг үүргийн дотоод харилцааг албажуулах, ажлын гүйцэтгэл, баримт бичиг боловсруулах, хянахад ашиглан ажиллаж байна. Байгууллагын үндсэн 68 ажилтныг ERP ийн системд бүртгүүлсэн төрийн байгууллагын дотоод холбооны шуурхай байдлыг хангаж ажиллаж байна.

Нийт үндсэн 74 ажилтнаас 69 ажилтнуудыг хамрагдуулсан.



*Зураг 57 Дотоод холбоо*

## ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

**Зорилт 1.** Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй, хариуцлагатай төрийн албыг бүрдүүлэх зорилтын хүрээнд чиг үүргийнхээ хүрээнд нийт 7 удаагийн сургалтад хамрагдаж ажилласан.Захиргаа удирдлагын хэлтсийн Хуулийн мэргэжилтэн, Хүний нөөцийн мэргэжилтэн, Дотоод хяналт мониторингийн мэргэжилтэн нар 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр "Хяналт, үнэлгээ шинжилгээ хийх сургалт", Хүний нөөцийн мэргэжилтэн, Санхүүгийн албаны Ерөнхий нягтлан бодогч, цалингийн нягтлан бодогч, нар Нийгмийн даатгалын тулгамдсан асуудал зэрэг сургалтуудад хамрагдсан.

Хяналт үнэлгээ шинжилгээний мэдээлэл сургалт

*Арга хэмжээ 4.1.1* Байгууллагын "Ёс зүйн зөвлөл"-ийн 2025 оны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

Байгууллагын Ёс зүйн зөвлөлийг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр 5 ажилтны бүрэлдэхүүнтэй байгуулж, ажилтны гомдлын дагуу 11 дүгээр сард хурлаар хэлэлцэн, бусдыг ажил мэргэжлээр ялгаварлан гадуурхсан нь тогтоогдсон 2 ажилтанд сахилгын шийтгэл ноогдуулж, ёс зүйн журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. "Ёс зүйн зөвлөлийн"-ийн шийдвэрийн хүрээнд ажил сайжруулах чиглэлээр 2 удаагийн уулзалт, зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэсэн.



"ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ" ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 12 өдөр Дугаар А/125 Улаанбаатар хот

Ёс зүйн дүрэм батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын "Дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.7.3 дахь заалт, "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Үйлдвэрийн газрын нийт ажилтанууд дагаж мөрдөх ажилтны ёс зүйн дүрмийг хавсралтаар батлсугай.

2.Батлагдсон дүрмийг хэрэгжүүлж ажиллахыг Үйлдвэрийн газрын нийт ажилтнуудад үүрэг болгосугай.

3.Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ёс зүйн зөвлөлд даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Ц.Болормаад үүрэг болгосугай.

ДАРГА Б.БАТТУЛГА

*Зураг 58 Ёс зүйн дүрэм*

*Арга хэмжээ 4.1.2* "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай" 01,02,03,04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд сар бүрийн тайлан мэдээг тайлагнан хэрэгжилтийг хангаж байгууллагын төлөвлөгөөний дагуу тайлан мэдээг улирал бүр тайлагнан Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэн ажиллаж байна.



*Зураг 59 Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр*

*Арга хэмжээ 4.1.3 Дээд газраас ирсэн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.*

1. Агаарын чанарыг сайжруулах, хяналт шалгалтын чиглэлээр:
- Нийслэлийн Засаг даргын А/1276, А/1285 дугаар захирамжийн дагуу Шуурхай штабыг уртасгасан цагаар ажиллуулж, түүхий нүүрсний хэрэглээ болон агаарын чанарыг сайжруулах бүсийн журамд хяналт тавин, мэргэжил арга зүйн удирдлагаар хангав.
- Засгийн газрын 62 дугаар тогтоолын хэрэгжилтийн мэдээг 7-14 хоног тутамд Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газарт тогтмол хүргүүлж байна.
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцож, үйл ажиллагааг уялдуулан ажиллалаа.

2. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах чиглэлээр:
- Налайх дүүргийн Засаг даргын А/182 дугаар захирамжийн дагуу 2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг 100% хангаж, техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг бүрдүүлэв.
- Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг, камерын системийн найдвартай байдлыг хангах хөрөнгө оруулалтын ажлуудад хяналт тавьж ажиллалаа.

3. Худалдан авах ажиллагаа болон захирамжийн шинэчлэлийн хүрээнд:
- Нийслэлийн Засаг даргын А/1175, А/1617 дугаар захирамжуудын дагуу бараа, ажил үйлчилгээ худалдан авах, гэрээ байгуулах бэлтгэл ажлыг Төсвийн тухай болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж ажилласан.

*Арга хэмжээ 4.1.4 Дотоод хяналт, мониторингийн ажлыг зохион байгуулж байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт гаргах*

Дотоод хяналт, мониторингийн төлөвлөлтийн үе шатны ажлыг 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 10 дугаар сарын 30-ны өдрөөс, тайлагнах үе шатны ажлыг 11 дүгээр сарын 30-ны өдрөөс тус тус эхлэх ба хяналт шалгалтын тайланг 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор газрын даргын зөвлөлд танилцуулж зөрчлийг арилгуулах зөвлөмж өгч ажилласан.

*Арга хэмжээ 4.1.5* Төсвийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь гаргаж дээд шатны байгууллагад хүргүүлэх

Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэх нягтлан бодох бүртгэлийн маягт, хөтлөх аргачлал"-ыг мөрдлөг болгон, түүгээр батлагдсан нягтлан бодох бүртгэлийн журнал, ерөнхий дэвтэр болон тайлангийн маягтуудыг ашиглан ажиллав.

Сангийн сайдын тусгай зөвшөөрөлтэй "Интерактив Би Ай" ХХК-ийн "Diamond–5" санхүүгийн программ, цалин хөлсний тооцоололд "Payroll" зэрэг хэрэглээний программуудаар тооцоолол хийж, 550–574 орчим ажилтанд нийт 3,951,194,100 төгрөгийн цалин хөлс, унаа хоолны нэмэгдэл, НДШ болон бусад шимтгэлтэй холбоотой тооцооллуудыг гүйцэтгэсэн. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл, тооцооллыг программд бүрэн шивж оруулснаар ажлын бүтээмж нэмэгдэж, тайлан баланс, мэдээг тогтоосон хугацаанд хүргүүлэх боломж бүрдсэн.

*Арга хэмжээ 4.1.6 Байгууллагын эд хөрөнгийн бүртгэлийг цаг хугацаанд нь хийж, эд хөрөнгийн ашиглалтын стандарт нормыг баримтлан ажиллах, Эд хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг НӨАУГ-т тавьж шийдвэрлүүлэн, өмчийн мэдээллийн нэгдсэн санд оруулах*

2025 онд НӨАУГ-тай байгууллагын даргын онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг байгуулж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд байгууллагын эд хөрөнгийн бүртгэлийг хугацаандаа хийж гүйцэтгэлээ.

Эд хөрөнгийн бүртгэлийг хийхдээ ашиглалтын стандарт, нормыг чанд мөрдсөн бөгөөд дараах төрлүүдийн нийт 220,823,000 төгрөгийн үнэлгээтэй үндсэн хөрөнгийг бүртгэв. Үүнд:

- Аж ахуйн материал – 22 нэр төрөл, 4,050,722 төгрөг
- Барилгын материал – 200 нэр төрөл, 41,199,218 төгрөг
- Шатах тослох материал – 10 нэр төрөл, 22,965,000 төгрөг
- Хангамжийн материал
  - ✓ Тавилга, эд хогшил – 287 нэр төрөл, 67,033,300 төгрөг
  - ✓ Компьютер болон дагалдах хэрэгсэл – 10 нэр төрөл, 127,147,000 төгрөг
- Бусад үндсэн хөрөнгө – 22 нэр төрөл, 25,461,063 төгрөг

Эдгээр хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой аливаа асуудлыг НӨАУГ-таа тухай бүр танилцуулж шийдвэрлүүлэн, баталгаажуулсан. Мөн бүртгэгдсэн бүх хөрөнгийн мэдээллийг өмчийн мэдээллийн нэгдсэн санд бүрэн оруулж, мэдээллийн төрөлжсөн сангийн бүртгэлийг шинэчлэн баталгаажуулсан болно.

*Арга хэмжээ 4.1.7* Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн Shilendans.gov.mn цахим сайтад 5 сая төгрөгөөс дээш гүйлгээг шивэх, холбогдох тушаал шийдвэрийг оруулах, Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөх, байгууллагын ил тод байдал, шилэн данс, шил ажиллагааны хуулийн хэрэгжилтийг хангуулах

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Shilendans.gov.mn цахим системд 5 сая төгрөгөөс дээш дүнтэй бүх гүйлгээг хугацаанд нь шивж, холбогдох тушаал, шийдвэрүүдийг тогтмол байршуулан ажиллав.
Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр тогтвортой ажилласан. 2025 оны 11 дүгээр сард Санхүүгийн шилэн дансанд аудит хийлгэж, аудитын дүгнэлтээр тайлан, мэдээллүүд 64.5 хувьтай үнэлгдэн баталгаажсан болно.

2025 оны Санхүүгийн үйл ажиллагааны баримт, тайлан балансанд аудит хийлгэж, баталгаажуулах

2026 оны төсвийн төсөөлөл болон бизнес төлөвлөгөөг боловсруулан, дээд шатны удирдлагад танилцуулж, хэлэлцүүлэн батлуулсан. Мөн байгууллагын 2025 оны III улирлын санхүү, гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь хүргүүлж, одоогоор холбогдох байгууллагаас шалгаж байна.

## ТАВ. МЭРГЭЖИЛИЙН УР ЧАДВАР ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Зорилт 1. Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгох зорилтын хүрээнд

*Арга хэмжээ 5.1.1* Ажил үүргийн хуваарьтай холбоотой хууль тогтоомжийг судлах, дээд газраас зохион байгуулж буй сургалтад ажилтнуудыг чиг үүргийн дагуу хамруулах.

Тайлант хугацаанд байгууллагын ажилтнуудыг ажлын чиг үүрэгт нь нийцүүлэн, мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (НЗДТГ) болон холбогдох бусад байгууллагуудаас зохион байгуулсан сургалтуудад идэвхтэй хамруулсан. Үүнд:
-2025 оны 06 дугаар сарын 12: НЗДТГ-аас зохион байгуулсан "Хяналт Шинжилгээ Үнэлгээ хийх журмын танилцуулга" сургалтад Хүний нөөцийн мэргэжилтэн оролцсон.

-2025 оны 10 дугаар сарын 05: НЗДТГ-ын Хяналт Шинжилгээ Үнэлгээний газраас зохион байгуулсан "Байгууллагын үйл ажиллагаанд Хяналт Шинжилгээ Үнэлгээ хийх тухай 43-р тогтоол танилцуулах" сургалтад Гэрээ хуулийн мэргэжилтэн, Дотоод хяналт болон Хүний нөөцийн мэргэжилтнүүд хамрагдсан.

2025 оны 10 дугаар сарын 15: НЗДТГ-ын Хүний нөөцийн хэлтсээс зохион байгуулсан "Хүний нөөцийн цахим систем танилцуулах" сургалтад Хүний нөөцийн мэргэжилтэн оролцсон.



*Зураг 60 Хүний нөөцийн цахим систем танилцуулах сургалт*

2025 оны 11 дүгээр сарын 04: Сүхбаатар дүүргийн Нийгмийн Даатгалын (НД) хэлтсээс зохион байгуулсан "Нийгмийн даатгалын тулгамдсан асуудал" сургалтад Ерөнхий нягтлан бодогч, Цалингийн нягтлан бодогч болон Хүний нөөцийн мэргэжилтнүүд хамрагдсан.



*Зураг 61 Нийгмийн даатгалын тулгамдсан асуудал сургалт*

*Арга хэмжээ 5.1.2* Ажилтнуудад мэргэжлийн болон бусад ур чадварын эзэмшүүлэх зорилгоор байгууллага доторх болон бусад байгууллагаас хэрэгжүүлж буй сургалт, арга хэмжээнд хамруулах.

Байгууллагын үйл ажиллагааны чанар, ажилтнуудын харилцааны ур чадварыг сайжруулах зорилгоор дотоод болон гадаадын мэргэжилтнүүдийн зохион байгуулсан дараах сургалтуудад ажилтнуудыг хамруулсан:

Албан хэрэг хөтлөлт ба E-Doc системийн хэрэглээ: 2025 онд Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан сургалтад 15 ажилтан хамрагдсан.

"Харилцаа хандлага, Байгууллагын зан төлөв" сэдэвт сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр байгууллагын төв оффист Судлаач Доктор, Дэд профессор Б.Оюун-Эрдэнийн удирдсан энэхүү чухал сургалтад нийт 30 ажилтан оролцсон.

*Арга хэмжээ 5.1.2 Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах*

Хийн газын анхан шатны сургалт: 2025 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр Нийслэлийн Онцгой Байдлын Ерөнхий Газраас (НОБЕГ) зохион байгуулсан аюулгүй байдлын сургалтад 3 ажилтан тус тус хамрагдсан.



*Зураг 62 НОБЕГ сургалт*

*Арга хэмжээ 5.1.2 Ажилтнуудын ажлын онцлогт тохирсон шат шатны ХАБЭА-н сургалтуудыг зохион байгуулж, мэдлэг ур чадварыг дээшлүүлэхэд шаардлагатай дадлага сургуулилтыг давтамжтай, үр дүнтэй зохион байгуулах*

Сонгинохайрхан дүүргийн Улаанзагалмайн нийгэмлэгтэй хамтран 2025 оны 05 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд нийт 473 ажилтанд хоёр өдрийн сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтад 413 хяналтын ажилтан, 20 засварчин, 15 оператор, 25 оффисын албан хаагч хамрагдсан бөгөөд *"Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх"*, *"Галын аюулын үед авах арга хэмжээ"*, *"Үйлдвэрийн ослын үед авах арга хэмжээ"* зэрэг сэдвүүдээр мэдлэг олгов.



*Зураг 63 НОБЕГ туршилтын сургалт*

Байгууллагын удирдлагын санаачилгаар 7 дүүргийн гэрээт хяналтын ажилтнууд болон дүүрэг хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан "Эрч хүчтэй өглөө" уулзалт, сургалтыг зохион байгуулсан.

Тус сургалтын хүрээнд ХАБЭА-н зааварчилгааг хэрхэн зохих шаардлагын дагуу өгөх, өдөр тутмын дасгал хөдөлгөөнд хэвших дадлыг төлөвшүүлэх, зөв галлагааны стандартыг таниулах зэрэг сургалтуудыг явуулж, шинээр ажилд орсон ажилтнуудад байгууллагын ерөнхий танилцуулга мэдээллийг өгч, хүний нөөцийн багтай уулзуулах, тулгамдсан асуудлаар зөвлөгөө мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн ажиллав.

"Эрч хүчтэй өглөө" сургалтыг дараах хуваарийн дагуу зохион байгуулсан. Үүнд:

- ✓ 2025.09.17-Чингэлтэй дүүрэг
- ✓ 2025.09.18-Сүхбаатар дүүрэг
- ✓ 2025.09.19-Сонгинохайрхан дүүрэг
- ✓ 2025.09.20-Хан-Уул дүүрэг
- ✓ 2025.09.24-Налайх дүүрэг
- ✓ 2025.09.26-Баянгол дүүрэг
- ✓ 2025.09.30-Баянзүрх дүүрэг

Сургалтад нийт 465 хяналтын ажилтан хамрагдаж, ажилтнуудын идэвх, өөрийгөө хөгжүүлэх хандлага, ажлын гүйцэтгэлийн зохион байгуулалт сайжрах нөхцөлийг бүрдүүлсэн.



*Зураг 64 Эрч хүчтэй өглөө уулзалт*

БОЛОВСРУУЛСАН:МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН ДАРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ — О.ДЭЛГЭРМӨРӨН

ХЯНАСАН:ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА — Ц.БОЛОРМАА

ТАНИЛЦСАН: ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ДАРГА — Б.БАТТУЛГА